

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

№ 22/26

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын Репо арилжаанд оролцох эрхийг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22, 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 22/12 тоот тогтоол, Компанийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн эх үүсвэрийг үр ашигтай удирдах зорилгоор Репо арилжаанд зээлдэгч болон зээлдүүлэгчийн хувиар оролцоход баримтлах арилжааны хэмжээг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолоор шинэчлэгдсэн батлагдсан арилжааны хэмжээний дагуу Репо арилжаанд оролцох, арилжааны хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан Компанийн хэвийн зээлийн багцыг нэмэгдүүлсэн хэмжээнээс тооцон нэмж барьцаалах, эдгээр үйл ажиллагааны хүрээнд “Мони Маркет Фанд” ХХК-тай нэмэлт гэрээ, хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
3. Репо арилжаанд оролцохдоо Компанийн эрх ашиг болон дотоод бодлогод нийцүүлэн оновчтой тодорхойлох, үр ашигтай түвшинд удирдан зохион байгуулж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Компанийн ТУЗ-д тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

№ 22/27

Улаанбаатар хот

Үнэт цаас хаалттай хүрээнд санал болгон гаргах тухай

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт, 76 дугаар зүйлийн 76.1.5 дах заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Компанийн өрийн бичиг (цаашид “Бонд” гэх)-ийг хаалттай хүрээнд санал болгон гаргахаар шийдвэрлэсүгэй.
2. Хаалттай хүрээнд санал болгох Бондын хэмжээ, ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Компанийн Бондыг хаалттай хүрээнд санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан оролцогч бусад эрх бүхий этгээдтэй энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд холбогдох хэлцэл хийх, гэрээ байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
4. Компанийн Бондыг хаалттай хүрээнд санал болгон гаргахтай холбоотой судалгаа шинжилгээ хийх, тэдгээрийн үйл явц, хэрэгжилт, үр дүнг Компанийн ТУЗ-д танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.
5. Компанийн Бондыг хаалттай хүрээнд санал болгон гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын журамд нийцүүлэн зохион байгуулах, шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, бусад шаардлагатай арга хэмжээ авах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

№ 22/28

Улаанбаатар хот

2022 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг өөрчлөн сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийхээр сонгогдсон “Мэдээлэл-Аудит” ХХК-ийн үйлчилгээний төлбөр өссөнтэй холбогдуулан “Мэдээлэл-Аудит” ХХК-тай байгуулсан гэрээг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөр дуусгавар болгохоор шийдвэрлэсүгэй.
2. “Мэдээлэл-Аудит” ХХК-тай байгуулсан гэрээг дуусгавар болгож байгаатай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 22/23 тоот тогтоолын “Мэдээлэл-Аудит” ХХК-тай холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.
3. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК-ийг сонгосугай.
4. “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК-тай байгуулах холбогдох гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
5. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.

